



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 4/102

Хажуу шинэ ус

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйл, Газрын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Говь-Угтаал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2021 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн №25 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

1. Цагаандэлгэр сумын нэг малчин иргэн, Дэрэн сумын нэг малчин иргэн, Гурвансайхан сумын нэг малчин иргэнд өвөлжөө хаваржааны зориулалтаар хавсралтад зааснаар эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмших хугацааг 15 жил, газрын хэмжээг 5000м² байхаар олгохыг газрын даамал (Б.Хорол)-д үүрэг болгосугай.
3. Эзэмшил газрын хил заагийг тогтоон газрыг хүлээлгэн өгч, гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Б.Хорол)-д даалгасугай.
4. Газрыг зориулалтын дагуу байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр эзэмшиж гэрээнд заасан үүргээ биелүүлж байхыг газар эзэмшигч иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө. МӨНХ-АМГАЛАН

482201102

Засаг даргын 2022 оны 10
дугаар сарын 27-ны өдрийн 4/22
тоот захирамжийн хавсралт

**ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ ЗОРИУЛАЛТААР ГАЗАР ЭЗЭМШИХ ИРГЭДИЙН
НЭРС**

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Баг	Газрын нэр
1.	Бярзав	Батмөнх	ЗЮ40050510	Цагаандэлгэр сум 1-р баг	Хөвийн хар
2.	Пүрэв	Дамбарэнцэн	ЗЖ68070914	Дэрэн сум 4- р баг	Говийн бууц
3.	Халтар	Гурвантамир	ЗГ78022616	Гурвансайхан сум 1-р баг	Хошуун бууц